

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

Даяаршлын эринд ажиллаж, амьдрах чадвартай, өндөр мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэж, Монгол орныхоо одоо, ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулна.

ЗОХИОМЖ ХЭВЛЭЛИЙН ЗОРИЛГО

Зохиомж дээд сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтанууд болон бакалавр, магистрын зэргээр өдөр болон оройн ангид сурч буй нийт оюутануудыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орчныг бүрдүүлэхэд оршино.

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм оюутнууд аа, Олон Улсын Бизнес Технологийн Зохиомж Дээд сургууль нь Монгол Улсын дээд боловсролын хурдацтай хөгжин дэвшиж дүй тэргүүний байгууллага юм.

Тус сургуульд элсэн орсон эх орны чадварлаг ирээдүй оюутан залуус та бүхний нэгэн цөийн түүхийг амжилт бүтээл, амьдралаараа дичилцэж гэгээн цүйлэт хөтлөж замыг бид халтгаа дүй болгохоор эрдмийн их өргөөндөө журан цугларлаа. Эх орон, хүн төрөлхтний хүмүүнлэг цүйлэт хувь нэмрээ оруулах, Зохиомж их сургуулийг цогцлоож зорилт бидэнд бий.

Хүн бүгдэд адил эхлэл, ижил заяа, боломж байдаг чамьдралд олон өнгө зэрэгцэн байдаг. Хичээж, өөрийгөө дайчлан суралцаж чадаан нь эрдэм ухааныг олж авч насан туршидаа ухаанарт амьдралаа зориулах мэргэжлээ чадварлаг эзэмшдэг.

Амжилтын шигдэт түлхүүр-хичээл зүтгэл билээ. Эрхэм оюутнууд та нартаа амжилт хүсье.

Б.ЦОГТМБАЯР

Улсын төсөвт 989.1 тэрбум төгрөг төвлөрүүлжээ



Уул уурхайн салбараас энэ оны эхний найман сард улсын төсөвт нийт 989.1 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Харин сайдын багцын орлого нь 186.3 тэрбум төгрөг болжээ. Уул уурхайн сайдбагцын орлогод Ашигт малтмалын газар нийт 27 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнээс ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 24.5 тэрбум төгрөг, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр 1.3 тэрбум төгрөг, бусад орлого 1.2 тэрбум төгрөгийг бүрдүүлжээ. Харин Газрын тосны газар нийт 159.3 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлснээс 158 тэрбум төгрөг нь газрын тосны орлого, 1.3 тэрбум төгрөг нь бусад орлого аж.

Валютын ханш

	АНУ доллар	1,840.91
	Евро	2,335.19
	Японы иен	16.83
	Швейцар франк	1,935.05
	Шведийн крон	254.36
	Английн фунт	2,994.42
	ОХУ-ын рубль	46.75
	БНХАУ-н юань	299.70
	БНСУ-ын вон	1.75
	Канадын доллар	1,651.11
	Малайзын ринггит	562.88
	Туркийн лира	809.55



БИЗНЕСИЙН СУРГУУЛИУД, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ЗӨВЛӨЛ

ACBSP нь АНУ-ын Канзас мужид байрладаг бөгөөд Эдийн засаг бизнесийн чиглэлийн сургууль, хөтөлбөрт магадлан итгэмжлэл олгодог байгууллага.

Зохиомж дээд сургууль нь ACBSP-н эрхэм зорилго, үнэт зүйлс ба үзэл баримтлалыг хүндэтгэлтэйгээр хүлээн зөвшөөрч, мэргэжлийн хөтөлбөрийн олон улсын магадлан итгэмжлэлийн ашиг тустай байдлыг чухалчлан үзэж 2012 оны 6 сард албан ёсоор гишүүнчлэлээр элссэн.

ACBSP-ээс жил тутам зохион байгуулагддаг ээлжит Эрдэм шинжилгээний хурал 2013 оны 6 дугаар сарын 20-24-ны өдрүүдэд АНУ-ын Salt Lake хотноо зохион байгуулагдаж тус сургууль ACBSP-ийн Candidate/нэр дэвшигч/-аа гардан авсан.

Нийт 47 орны 930 гаруй сургалтын байгууллага ACBSP-ийн гишүүн бөгөөд эдгээр орнуудыг 10 бүс болгон хуваадаг.

Жилд олон улсын хэмжээнд 10 шилдэг багшийг шалгаруулдаг бөгөөд Д.Энхжин /Ph.D/ захирал 8 дугаар бүсийн шилдэг багшаар шалгарсан юм.

Магадлан итгэмжлэгдэх нь суралцагчдад ямар ач тустай вэ?

- Магадлан итгэмжлэл нь оюутнуудын хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багш нарыг оюутнуудтай илүү хүртээмжтэй ажиллахад түлхэц болдог
- Магадлан итгэмжлэгдсэнээр оюутнуудад чанартай мэргэжил олгох бүрэн боломжоор хангаж өгдөг.
- Магадлан итгэмжлэгдсэнээр оюутнуудын сурах бололцоог бүрэн хангасан орчин үеийн сургалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, материаллаг баазтай байх шаардлага тавигддаг нь оюутнуудад хэрэгтэй зүйлийн тоонд зайлшгүй орно.
- Оюутанд үзүүлэх үйлчилгээ нь үргэлж шинэчлэгдэж, нэмэгдэж байдаг.
- Төгсөгч нь ажилд орохдоо магадлан итгэмжлэгдсэн сургууль, хөтөлбөрөөр төгссөнөө CV дээрээ бөглөж өгдөг. Ингэснээр гадаадад эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах, нэр хүндтэй байгууллагад ажилд орох боломж нээгдэж өгнө.

Зохион байгуулагдсан ажлууд



- 411-712, 412-812 ангийг М.Уранчимэг, 416-12, 416-13 ангийг П.Оргилмаа, 413-13, 414-13, 413-14 ангийн З.Болорчимэг, 416-12, 416-13, ангийг П.Энхнасан багш нар зөвлон ажиллахаар болов.
- Бизнес Удирдлагын Тэнхмийн багш нар оюутнуудад мэдлэг чадвар олгох зөвлөгөө өгөх цагийн хуваарь гарган ажиллаж байна.
- Бизнес Удирдлагын Тэнхмийн 1-р курсын оюутнуудын эцэг эхийн хурлыг тэнхмийн эрхлэгч, ангийн багш, тэнхмийн багш нарын бүрэлдэхүүнтэйгээр хийсэн. Энэ хурал дээр сургуулийн эрхэм зорилго, сургууль, багш нараа танилцуулж, цаашид хийх ажлын төлөвлөгөөний талаар ярилцсан. Хуралд хүрэлцэн ирсэн эцэг эхчүүд ихэд сэтгэл хангалуун байсан.

Гурилын үнийг тогтвортой байлгана



Ү Х А А Я - ны холбогдох албаныхан болон тариаланчид, гурил үйлдвэрлэгчид хуралдаад үтрэм нөхцөлөөр тонн ул а а н б у у д а й н үнийг 550 мянган төгрөг байхаар тогтжээ. Тэгэхдээ улаанбуудайн үнийг дагаж гурилын үнэ өсч болзошгүй учраас салбарын яамнаас нэгдүгээр гурилын бөөний үнийг 850 төгрөгөөс хэтрүүлэхгүй байхаар гурил үйлдвэрлэгчидтэй энэ үеэр тохиролцсон аж.Одоогийн байдлаар зах зээлд "Алтан тариа" компанийн нэгдүгээр гурил кг нь 810, "Хангай миллс" компанийнх 840 төгрөгөөр нийлүүлдэг. Нөгөөтэйгүүр, Засгийн газраас Монголбанктай хамтран хэрэгжүүлж буй "Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр"-т өнгөрсөн жил гурилын 26 компани хамрагдаж, нийт 48 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан. Эл хөтөлбөрт хамрагдсан үйлдвэрүүд нэгдүгээр гурилын үнийг бүтэн жилийн турш 850 төгрөгт барина хэмээн тооцож байна. Энэ хүрээнд ч гурилын үнийг хэрхэн, тогтвортой байлгах талаар яамны холбогдох албаныхан ажиллаж байгаа гэнэ.

Даатгуулагч жилд 132800 төгрөгийн хөнгөлөлт эдлэх эрхтэй



Эрүүл мэндийн даатгалын санд иргэд сар бүр хураамж төлдөг ч түүний ач холбогдол, үйлчилгээний талаар тэр бүр мэддэггүй. Тэгвэл

энэхүү сангаас цэнхэр дэвтрээр дамжуулан даатгуулагч жилд 132800 төгрөгийн хөнгөлөлт эдлэх эрхтэй бөгөөд 132 төрлийн эмийг 80 хүртэлх хувийн хөнгөлттэй үнээр худалдан авах боломжтой байдаг юм. Үнийн энэхүү хөнгөлөлтийг хувиар авч үзвэл хамгийн өндөр нь 93 хувиар, мөнгөн дүнгээр авч үзвэл 18000 төгрөгөөр хөнгөлөх эмүүд ч байдаг ажээ. Үүнд эрүүл мэндийн даатгал төлдөг 0-оос дээш насны бүх иргэн хамрагдах боломжтой юм. Гэвч энэ талаарх мэдлэг, ойлголт дутмаг учраас даатгал төлдөг ч улсын эмнэлэгт үзүүлж, хэвтэж байгаагүй гэх хүн олон бий. Тэд улсын эмнэлэг "оочир" дараалал ихтэй, цаг хугацаа их зарцуулдаг хэмээн цааргалж хувийн эмнэлэгт мөнгө төлөн эмчлүүлэх нь элбэг.

Тэгвэл даатгуулагч иргэн таны "цэнхэр дэвтэр" ямар ач холбогдолтой талаар мэдээлэл хүргэе.

Эрүүл мэндийн даатгалын сангаас "Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, үнэ, хөнгөлөх хувь, хэмжээ"-г баталсан байдаг. Үүний дагуу олон улсын нэршлээр 132, худалдааны нэршлээр 339 эмийг хөнгөлттэй үнээр олгохоор баталсан аж. Эмийн үнийн хөнгөлөлтөд ЭМ-ийн даатгал төлдөг 0-ээс дээш бүх насныхан эрүүл мэндийн даатгалын дэвтрийн хамт оршин суугаа хорооны өрхийн эмнэлгийн эмчдээ хандаж хамрагдах ёстой. Өрхийн эмчийн бичиж өгсөн тамгатай эмийн жорыг иргэний үнэмлэх, эрүүл мэндийн дэвтрийн хамт хавсарган "Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн сан" гэх хаягтай эмийн сангуудад үйлчлүүлснээр тухайн эмийг 80 хүртэлх хувиар хямдруулан авах боломжтой юм. Эмийн жор нь бичигдсэн өдрөөс эхлэн 10 хоногийн дотор хүчинтэй байх бөгөөд жоронд ямар нэгэн үг, үсгийн засвар ороогүй байх шаардлагатай аж. Мөн дашрамд дуулахад ЭМД-аас сүүлийн гурван жилд үйлчилгээ аваагүй иргэдэд 80000 төгрөгийн үзлэг оношлогоо үнэгүй хийхээр "Хаппи Варитас" төвийн шинэ салбар БГД-ийн 65-р хороо, Энхтайваны өргөн чөлөөнд нээгдсэн байна. Тиймээс иргэд ЭМД-ын "Цэнхэр дэвтэр"-ээ одооноос эхлэн ашиглаж, эрүүл мэнддээ анхаарч үнэгүй үзлэг, оношлогоонд хамрагдах боломж бүрдэж байгаа юм.

Татвар төлөгч та тайлангаа хэзээ хэрхэн ирүүлэх вэ?



- Та тайлангаа өөрийн биеэр болон цахим хэлбэрээр, мөн шуудангаар ирүүлж болно.
- Та татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд гаргаж татварын албанд ирүүлнэ. Жишээлбэл: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын улирлын тайланг улирлын дараа сарын 20-ны дотор, тухайн жилийн эцсийн тайланг дараа жилийн 2 дугаар сарын 10-ны дотор, НӨАТ-ын тайланг дараа сарын 10-ны дотор, онцгой албан татварын тайланг дараа сарын 5-ны дотор татварын албанд тушааж, татварын тооцоо хийнэ.
- Татвар төлөх, тайлагнах эцсийн хугацаа адил байдаг. Энэ нь тайлан хүргүүлэхдээ татвараа төлсөн байх ёстой гэсэн үг.
- Татвар тайлагнах хугацаа долоо хоног бүрийн амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхацвал түүний өмнөх ажлын өдөр татварын тайлангаа ирүүлнэ.
- Та татварын хуулийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдах бол тайлан тушаах үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд уг тайлан нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамруулах үндсэн баримт болно.

Энэ нөхцөлд та тайлангаа тайлбарын хамт өөрийн биеэр татварын албанд ирүүлэх ёстой гэдгийг анхаарна уу.

- Та татварын албанд ирүүлсэн тайлангаа тайлагнах эцсийн хугацаа хүртэл засварлах эрхтэй ба засварлах тухай хүсэлтээ бичгээр илэрхийлэх ёстой.
- Татварын алба тайлан хүлээн авсан хугацааг татвар төлөгч өөрийн биеэр ирүүлсэн тайлангийн хувьд уг тайланг татварын албанд хүлээн авч баталгаажуулсан өдрөөр, шуудангаар ирүүлсэн тайлангийн хувьд илгээсэн өдрөөр, интернетээр ирүүлсэн бол цахим мэдээллийн системд илгээсэн өдрөөр тооцно.



ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА "ЦААСГҮЙ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА"-Г НЭВТЭРҮҮЛЭЭ.



Монгол Улсын Гаалийн байгууллага нь Өмнөговь аймаг дахь Гашуун-Сухайтын Гаалийн боомт, Шивээ-Хүрэн дэх Гаалийн боомтоор экспортлогдож буй уул уурхай, ашигт малтмалын бүтээгдэхүүн болох нүүрс, газрын тос, төмрийн хүдэр, зэсийн баяжмал гэх мэт экспортын бараанд хийгдэх гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хөнгөвчлөх "ЦААСГҮЙ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ"-ийн технологид шилжих ажлыг амжилттай нэвтрүүлж эхлэлээ.

ЦААСГҮЙ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТЭД ШИЛЖИХЭЭС ӨМНӨ :

Экспортлогч гаалийн бүрдүүлэлт хийлгэхдээ бичиг баримтуудаа бүрдүүлэх, гаалийн зуучлагчаар дамжих, гаалийн мэдүүлгээ бичүүлэн, бараагаа мэдүүлэх зэрэг бүх үйл ажиллагаанд 5-6 гаалийн байцаагч ажиллаж, нэг ачилтад 27 орчим минут зарцуулагддаг, 20-29 шат дамжлагатай өртөг зардал бүхий үйлдлүүд хийгддэг байсан байна. Иймд экспортын барааны ачилтад хийгдэж буй шат дамжлага, зарцуулж буй цаг хугацаа, хүн хүч, үргүй зардал зэрэгт дүн шинжилгээ хийж ажилласнаар дараах үр дүнг гаргаад байна.

ЦААСГҮЙ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТЭД ШИЛЖСЭНЭЭР :

Экспортлогч барааг экспортлохоос өмнө гадаад худалдааны бичиг баримтуудаа гаалийн байгууллагад өгч хянуулсаны дараагаар экспортын ачилтаа эхлэх зарчимд шилжинэ. Үүнтэй уялдуулан гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд бүгд 3 байцаагч ажиллаж, нэг ачилтад 6-9 минут зарцуулж, 12-16 шат дамжлага бүхий үйлдлүүд хийгдэн, бараагаа гаалийн байгууллагад электрон хэлбэрээр өөрсдөө мэдүүлэх боломжоор хангагдсан байна.

Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг цаасгүй технологид шилжүүлснээр экспортлогч компанийн хувьд дараах үр ашгийг хүртэх боломжтой боллоо. Үүнд:

-Жин пүүний хэвлэмэл цаасан акт ашиглахаа

больж, аж ахуйн нэгжийн пүүний програмыг гаалийн байгууллагын цахим системтэй холбосон. -Тээврийн баримт /Хамтарсан манифест/-ыг бичих шаардлагагүй болсон.

-Гаалийн мэдүүлэг бичигдэж, бүрдүүлэлт хийгдсэний дараагаар тээврийн баримт автоматаар үүсэх боломжийг бүрдүүлсэн байна.

-Гадаад худалдааны бичиг баримтыг гаалийн мэдүүлэг бүрт хуулбарлан хавсаргах шаардлагагүй болсон.

Экспортын гаалийн бүрдүүлэлтийг цаасгүй технологид шилжүүлэх ажлыг хийснээр дараах үр ашиггүй зардалыг хэмнэх боломжтой болгосон.

Гаалийн байгууллагад:

-Манифестын хураамж тус бүрт 3000 төг

-Гаалийн мэдүүлэгт хилээр гаргасан тэмдэглэгээг хийлгэхээр өдөр бүр хил рүү авч явахад зарцуулдаг байсан зардал 60000-120000 төг

-Илгээгч байгууллагын гаалийн асуудал хариуцсан төлөөлөгч ажилтан /1 хүн/-ыг хилийн боомтод ажиллуулахад гаргадаг байсан зардал 25000-35000 төг

Зуучлагч байгууллагад:

-Тээврийн баримт /Хамтарсан манифест/-ын бичилтэд 3500-3700 төг

-Зуучлагч байгууллагын 2-3 ажилтанг уурхайн кемпид байрлуулах байр, хоолны зардал 8000-12000

-Пүүний актын баримт 3-5% маягтыг хэвлүүлэх төлбөрт 800-1500 төг

Жич: Дээрх бүх зардлыг нэг өдөрт экспортын ачилт хийгдэх тээврийн хэрэгсэлд хуваан хуваарилж үзэхэд, 1 ачилт тутамд 12000 төгрөгийн зардалыг хэмнэх тооцоо гарч байна.

Мөн барааг илгээгч байгууллага гаалийн зуучлагч байгууллагаар дамжуулан мэдүүлэхгүйгээр өөрсдөө бие даан мэдүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Экспортын бүрдүүлэлтийн нэг тээврийн хэрэгсэлд гарах зардал 12000 төгрөгийг өдөр бүр гаалийн хилээр нэвтэрч буй 800 автомашинаар тооцолбол :

Өдөр бүр 9,600,000 төгрөг

Сар бүр 288,000,000 төгрөг

Жилд дунджаар 3,456,000,000 төгрөг хэмнэж боломжийг бүрдүүлээд байна.